



ЗОН ОЛНЫ НАМЫН ДҮРЭМ

/ЗОН ОЛНЫ НАМЫН 8 ДУГААР БАГА ХУРЛААР НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН./

Монгол улс, Улаанбаатар хот
2019 он

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тус намыг “Зон Олны нам” гэж нэрлэнэ. Намын нэрийг “ЗОН” гэж товчилно. Англиар “Demos Party” гэнэ.
2. ЗОН нь Монгол улсын Үндсэн хуулийн хүрээнд ард олны сайн дураар нэгдсэн улс төрийн байгууллага мөн. Улс төрийн намын тухай хууль, Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
3. ЗОН-ын төв байгууллага Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана.
4. ЗОН нь Монгол улсын онцлогт тулгуурласан тогтвортой хөгжлийн гарцыг тодорхойлж, оюунлаг, эрүүл чийрэг, эрх чөлөөт, чинээлэг ард олонтой Монгол улсыг бий болгохын төлөө, неоконсерватив үзэл баримтлалыг улс төрийн чиг баримжаагаа болгоно.
5. Намын бэлгэдэл, далбаа, уриа
- 5.1. ЗОН-ын бэлгэдэл нь хөх өнгийн дэвсгэр дээр алтан шар өнгийн гал, нар, сар түүний доор нар зөв дотогш эргэсэн зөв дүрсийн хамт төв хэсэгт голлон байрлана. Түүний доор “ЗОН ОЛНЫ НАМ” гэсэн цагаан өнгийн крилл үсэг эсвэл Монгол бичиг байна.



5.2. ЗОН-ын далбаа 2:1 харьцаа бүхий урт, өргөнтэй байна. Далбаа нь хөх өнгийн дэвсгэр дээр алтан шар өнгийн гал, нар, сар түүний доор нар зөв дотогш эргэсэн зөв дүрсийн хамт төв хэсэгт голлон байрлана. Мөн бэлгэдэл доор “ЗОН ОЛНЫ НАМ” гэсэн цагаан өнгийн крилл үсэг эсвэл Монгол бичгээр бичсэн хувилбар бүхий далбаа байж болно.



5.3. ЗОН-ын уриа үг “МЭДЛЭГ ЯЛНА”

6. ЗОН-ын үндсэн зарчим

6.1. Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, халдашгүй байдлын төлөө бат зогсож, Монгол улсын төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчимд тууштай байна.

6.2. Эдийн засгийн эрх чөлөөг хүний эрхийн үндсэн баталгааны чухал хэсэг гэж үзнэ.

- 6.3. Шинжлэх ухаан, боловсрол, мэдлэг туршлагыг хүн ард, улс орны хөгжлийн түлхүүр гэж үзнэ.
- 6.4. Монгол үндэстний уламжлал, соёл ахуйг хүн ард, улс орны үнэлэшгүй баялаг мөн гэж үзнэ.
- 6.5. Хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байхыг тэгш эрхийн зарчим гэж үзнэ.
- 6.6. Чөлөөт өрсөлдөөнийг улс төрийн эрх чөлөөний чухал хэсэг гэж үзнэ.
- 6.7. Өнгөрсөн үеийн ололтыг хүндэтгэж, үргэлжлүүлэн залгамжилах нь өнөө цагийн бидний үүрэг гэж үзнэ.

7. ЗОН-ын гишүүний өргөх ТАНГАРАГ:

“Би агуу их Монгол үндэстний өмнө Монгол улсынхаа тусгаар тогтнол бүрэн эрхт байдлын төлөө үнэнч үлдэж, Монгол улсын Үндсэн Хууль, намын дүрмийг чанд сахин биелүүлэхээ тангараглая. ЗОН-ын гишүүн би өргөсөн тангарагаасаа няцвал Монгол улсын хууль, намын дүрмэнд заасан улс төрийн болон ёс суртахууны хариуцлагыг биечлэн хүлээнэ.”

ХОЁРДУГААР БҮЛЭГ НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛ

8. Намын гишүүнээр элсэх
 - 8.1. ЗОН-ын дүрэм, мөрийн хөтөлбөртэй танилцаж дэмжсэн бусад намд харьяалалгүй, 18 нас хүрсэн, Монгол улсын харьяат байна.
 - 8.2. Намын гишүүнээр элсэх хүсэлтээ ЗОН-ын албан ёсны цахим хуудсанд хандан гаргаж, “ЦАХИМ НАМ” системд бүртгүүлнэ.
 - 8.3. Гишүүнээр элсэх хүсэлтийг ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ.
 - 8.4. Гишүүнээр бүртгэж авах шийдвэр хүлээн авсан тохиолдолд гишүүний бат илэрхийлэхийг шуудангийн хүргэлтээр өөрийн оршин суугаа хаяг дээр авч болно. Мөн ЗОН-ын төв болон аль нэг салбар нэгжээс өөрийн биеэр авна.
 - 8.5. Оршин суугаа хаягт албан ёсоор өөрчлөлт орсон бол ЗОН-ын албан ёсны цахим хуудсанд хандаж, “ЦАХИМ НАМ” системд бүртгүүлсэн намын гишүүнчлэлийн хаягийн мэдээллээ өөрчилж шилжилт хөдөлгөөн хийлгэнэ.
 - 8.6. Гадаад улсад оршин суугаа Монгол улсын харьяат 8.2-т заасан байдлаар намын гишүүнээр элсэх хүсэлтээ гаргаж болно.

- 8.7. Намын бат илэрхийлэх нь зөвхөн ЗОН-ын гишүүн мөн гэдгийг тодорхойлно.
- 8.8. “ЦАХИМ НАМ” системд гишүүдийн бүртгэлийн нэгдсэн мэдээлэл төвлөрч давхар бүртгэл үүсэхгүй.
9. Намын гишүүний эрх
- 9.1. Улс төрийн намын тухай хуульд заасан эрхийг эдэлнэ.
- 9.2. Намаас явуулж буй үйл ажиллагаанд оролцох.
- 9.3. Намын бүх шатны байгууллагын сонгуульт албан тушаалд өөрийн эсвэл бусдын нэрийг дэвшүүлэх, сонгох, сонгогдох.
- 9.4. Монгол улсын Ерөнхийлөгч, УИХ, орон нутгийн сонгуульд намаас нэр дэвшигчийн талаар санаа бодлоо илэрхийлэх, санал тавих.
- 9.5. Намын санхүүжилт, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах.
- 9.6. ЗОН нь Монгол улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, Монгол улсын бусад хууль тогтоомж, намын дүрмийн хүрээнд намын гишүүнээ үзэл бодлынх нь хувьд хамгаална.
10. Намын гишүүний үүрэг
- 10.1. Монгол улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, Монгол улсын бусад хууль тогтоомж, намын дүрмийг мөрдөх.
- 10.2. Төрийн, орон нутгийн сонгуульд намаас нэр дэвшигчтэй зэрэгцүүлэн бие даан нэрээ дэвшүүлэхгүй байх.
- 10.3. Намын гишүүний хувьд Монгол улсын болон намын дотоод эв нэгдэлд сөрөг нөлөө үзүүлэх аливаа хэлбэрийн үйлдэл хийхгүй байх.
- 10.4. Бусад улс төрийн намын нэр хүндэд халдахгүй байх, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс орохгүй байх, бусдыг ямар ч тохиолдолд намын харьяаллаар ялгаварлахгүй байх.
- 10.5. Намаас аливаа ажил, албан тушаалд сонгогдож, томилогдсон этгээд хуулийг чандлан сахих.
- 10.6. Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дах хэсгийг дагаж мөрдөх.
11. Намын гишүүнээс түдгэлзэх, гишүүнчлэлээ сэргээх
- 11.1. Монгол улсын холбогдох хууль тогтоомжинд заасан үндэслэлээр намын гишүүнээс түдгэлзэх бол энэ тухай намын байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

- 11.2.Түдгэлзэх үндэслэл дууссан бол гишүүнчлэлээ сэргээх хүсэлтээ намын байгууллагад гаргаж, гишүүнчлэлээ сэргээнэ.
12. Намын гишүүнээс гарах, гишүүнчлэл дуусгавар болох
- 12.1.Өөрийн хүсэлтээр намаас гарсан.
- 12.2.Өөр намын гишүүн болсон.
- 12.3.Хуульд заасан бусад үндэслэлээр.
- 13.Бусад
- 13.1.Намын бүх шатны байгууллагын сонгуульт албан тушаалд сонгогдсон гишүүнийг сонгуульт гишүүн гэнэ. Сонгуульт гишүүний эрх үүрэг, түүнтэй холбогдох үйл ажиллагааг журмаар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ НАМЫН БАЙГУУЛЛАГА

14. ЗОН нь дараах бүтэцтэй байна:
- 14.1.Намын анхан шатны байгууллага аймаг, дүүргийн намын хороо.
- 14.1.1. Аймаг, дүүргийн намын хорооны хурал.
- 14.1.2. Аймаг, дүүргийн намын хорооны дарга.
- 14.2.Тойрог, Нийслэлийн намын хороо. Тойргийн намын хороо нь:
- **Төв** тойргийн намын хороо;
/Өвөрхангай, Төв, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Дундговь, Өмнөговь аймгууд хамаарна/
 - **Зүүн** тойргийн намын хороо;
/Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгууд хамаарна/
 - **Баруун** тойргийн намын хороо;
/Архангай, Хөвсгөл, Завхан, Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Баян-Өлгий аймгууд хамаарна/ зэрэг болно.
- 14.2.1. Тойрог, Нийслэлийн намын хорооны хурал.
- 14.2.2. Тойрог, Нийслэлийн намын хорооны дарга.
- 14.3.ЗОН-ын удирдах дээд байгууллага нь намын Их хурал мөн.
- 14.4.ЗОН-ын Их хурлын чөлөөт цагт намын төлөөллийн төв байгууллага Бага хурал /БХ/.
- 14.4.1. Зон Олны намын удирдлага

- ЗОН-ын Дарга.
 - ЗОН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга.
 - ЗОН-ын дэргэдэх Мэдлэг Онолын Нэгдэл /МОН/-ийн дарга.
- 14.5. Намын хяналтын төв байгууллага нь Хяналтын ерөнхий хороо /ХЕХ/.
- 14.5.1. Хяналтын Ерөнхий Хорооны хурал.
- 14.5.2. Хяналтын Ерөнхий Хорооны дарга.
- 14.6. Бага хурлын чөлөөт цагт гүйцэтгэх удирдлагын байгууллага нь Удирдах Зөвлөл /УЗ/.
- 14.6.1. Удирдах Зөвлөлийн хурал.
- 14.6.2. ЗОН-ын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх байгууллага Зохицуулалт Ажлын Албатай /ЗАА/ байна. Зохицуулалт Ажлын Алба /ЗАА/-ны даргыг ЕНБД томилно.
- 14.6.3. ЗОН нь гурав хүртэл нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн даргыг Удирдах Зөвлөлийн хурлаас томилно.
- 14.7. Намын дотоод асуудал хянан хэлэлцэх Дотоод арбитрын хороо /ДАХ/.
- 14.8. Намын Эрдэм шинжилгээний байгууллага Мэдлэг Онолын Нэгдэл /МОН/.
- 14.8.1. Мэдлэг Онолын Нэгдэл /МОН/-ийн дарга.
- 14.8.2. Мэдлэг Онолын Нэгдэл /МОН/-ийн зөвлөл.
- 14.8.3. Мэдлэг Онолын Нэгдэл /МОН/-ийн зөвлөлдөх хурал
- 14.9. Намын дэргэдэх байгууллага болох холбоо, клуб байж болно. Дэргэдэх холбоо, клуб нь үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалтаа Зон Олны намын дүрэм, үзэл баримтлалын хүрээнд зохицуулна. Үүнд:
- Шинээр зохион байгуулалтанд орж намын дэргэд холбоо, клуб үүсгэж болно.
 - Шалгуурт нийцэх төрийн бус байгууллагууд Зон Олны намын дэргэдэх байгууллагаар нэгдэж болно.
 - Хилийн чанад дахь Монголчуудын цахим нэгдэл, холбоо, клубууд.

15. НАМЫН АНХАН ШАТНЫ БАЙГУУЛЛАГА

15.1. Намын анхан шатны байгууллага нь аймаг, дүүргийн намын хороо байна. Аймаг, дүүргийн намын хороог тухайн засаг захиргааны нэгжид харьяалалтай бүх гишүүдийн хурлаас байгуулна. /Тайлбар: Хэнтий аймгийн ЗОН-ын хороо, Сүхбаатар дүүргийн ЗОН-ын хороо гэж нэрлэнэ./

- 15.2. Аймаг, дүүргийн бүх гишүүдийн хурлаас аймаг, дүүргийн намын хорооны гишүүдийг 9-11 хүний бүрэлдэхүүнтэй нууц санал хураалтаар сонгоно.
- /Тайлбар: Хэнтий аймгийн ЗОН-ын хорооны гишүүн, Сүхбаатар дүүргийн ЗОН-ын хорооны гишүүн гэж нэрлэнэ./
- 15.3. Аймаг, дүүргийн намын хороо нь хуралтай байна.
- 15.4. Аймаг, дүүргийн намын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно. Хуралд оролцсон намын хорооны гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчинтэй болно.
- 15.5. Аймаг, дүүргийн намын хороо даргатай байж болно. Бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна.
- /Тайлбар: Хэнтий аймгийн ЗОН-ын дарга, Сүхбаатар дүүргийн ЗОН-ын дарга гэж нэрлэнэ./
- 15.6. Аймаг, дүүргийн намын хорооны даргыг намын хорооны хурлаас нууц санал хураалтаар сонгоно.
- 15.7. Намын анхан шатны байгууллагын бүх гишүүдийн хурлыг дөрвөн жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.
- 15.8. Аймаг, дүүргийн намын хорооны хурлыг жилд 1-ээс доошгүй удаа хуралдуулна.
- 15.9. Аймаг, дүүргийн намын хороо нь ЗОН-ын Их хурал, Бага хурал, Удирдах зөвлөл, намын дарга, Тойрог, Нийслэлийн намын хороо болон даргын гаргасан албан ёсны бодлого, шийдвэрийг тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 15.10. Аймаг, дүүргийн намын хороо нь аймгийн сум, дүүргийн хороо болон түүнээс доош бүх шатны сонгуульд оролцох, тухайн шатны ИТХ-ын дарга, ИНХ-ын дарга, Засаг даргад нэр дэвшүүлэх болон намаас сонгогдож томилогдсон аливаа албан тушаалтан, гишүүдийн ажилд үнэлэлт, дүгнэлт өгч, намын хяналтын байгууллага, намын Их хурал, Бага хуралд санал оруулна.
- 15.11. Тойрог, Нийслэлийн намын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх.
- 15.12. Төрийн болон орон нутгийн сонгуулийн үед намаас нэр дэвшигчдийг дэмжих.
- 15.13. Дэмжигчдийн эгнээг өргөтгөж, мөрийн хөтөлбөр, үзэл баримтлалыг түгээх.

15.14. Намаас санаачлан гаргах улс төрийн боловсрол олгох мэдээ мэдээллийг түгээх.

16. ТОЙРОГ, НИЙСЛЭЛИЙН НАМЫН ХОРОО

16.1.1. Тойрог, Нийслэлийн намын хорооны гишүүдийг Тойрог, Нийслэлийн намын хороонд хамаарах аймаг, дүүргийн намын хорооны гишүүдээс сонгоно. Тойрог, Нийслэлийн намын хороо тус бүр 11 гишүүнтэй байна.

16.1.2. Тойрог, Нийслэлийн намын хорооны хуралд гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно. Намын хорооны гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчинтэй болно.

16.1.3. Тойрог, Нийслэлийн намын хорооны даргыг намын Бага хурлаас сонгоно.

16.2. Тойрог, Нийслэлийн намын хорооны эрх, үүрэг:

16.2.1. Намын анхан шатны байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, дэмжлэг үзүүлэх, зөвлөх үүрэгтэй.

16.3. ЗОН-ын Их хурал, Бага хурал, Удирдах зөвлөл, намын дарга, Тойрог, Нийслэлийн намын хорооны даргын гаргасан албан ёсны бодлого, шийдвэрийг тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх үүрэгтэй.

16.4. Тойрог, Нийслэлийн намын хороо нь аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох, мөрийн хөтөлбөр батлах, тухайн шатны ИТХ-ын дарга, Засаг даргад нэр дэвшүүлэх болон намаас сонгогдож томилогдсон аливаа албан тушаалтан, гишүүдийн ажилд үнэлэлт, дүгнэлт өгч, намын хяналтын байгууллага, намын Их хурал, Бага хуралд санал оруулна.

16.4.1. Монгол улсын Ерөнхийлөгчид болон УИХ-ын гишүүнд нэр дэвшүүлэх хүмүүсийн талаар санал гаргах.

16.4.2. Иргэдийн төлөөлөгчдийн хурал дахь ЗОН-ын бүлэгт чиглэл өгөх.

16.4.3. Намын боловсон хүчний эгнээг бэхжүүлэх.

16.4.4. Намын санхүүжилтийг бэхжүүлэхэд тус дэм үзүүлэх.

16.4.5. Тойрог, Нийслэлийн намын хорооны хурлыг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.

16.4.6. Тойрог, Нийслэлийн намын хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хангах ажлын албатай байж болно.

17. НАМЫН ИХ ХУРАЛ

- 17.1. Намын Их хурал дөрвөн жилд нэг удаа хуралдана. Ээлжит бус Их хурлыг Бага хурлын гишүүдийн гуравны хоёроос дээш бүрэлдэхүүний саналаар зарлан хуралдуулна. Ээлжит бус Их хурал ээлжит Их хурлын адил бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 17.2. Намын Их хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ
- 17.2.1. Намын дүрэм, мөрийн хөтөлбөр батлах.
- 17.2.2. Бага хурал, Хяналтын ерөнхий хорооны гишүүдийг нууц санал хураалт явуулж сонгоно. Мөн тэдгээрийн ажлын тайланг хэлэлцэх.
- 17.2.3. Намыг өөрчлөн байгуулах, татан буулгах, намын нэрийг өөрчлөх.
- 17.2.4. Намын бодлогын бүхий л асуудлыг хэлэлцэж болно.
- 17.2.5. Намын Их Хуралд сонгогдсон нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол Их Хурлыг хүчинтэйд тооцно. Төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэр хүчинтэй болно.
- 17.2.6. Хурлын дэгийг Хурал өөрөө тогтоож, хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу хэлэлцэнэ.
- 17.2.7. Улс төрийн намын тухай хууль тогтоомжинд заасан бусад асуудал.

18. НАМЫН БАГА ХУРАЛ

- 18.1. Намын Бага хурал 33-261 гишүүнтэй байна. Намын Их хурлаас Бага хурлын гишүүдийг сонгохдоо УИХ-ын гишүүн, нийслэл, аймгийн засаг дарга, тойрог, нийслэлийн намын хорооны дарга, Мэдлэг Онолын Нэгдэл, намын дэргэдэх байгууллага, орон нутгийн намын гишүүдийн төлөөллийг оролцуулан нэр дэвшүүлж, нууц санал хураалт явуулж сонгоно.
- 18.2. Бага хурлын гишүүдийн 20-оос дээш хувь нь эмэгтэйчүүдийн төлөөллөөс бүрдэнэ.
- 18.3. Намын ээлжит Бага хурал жилд нэгээс доошгүй удаа хуралдана.
- 18.4. Бага хурал болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө хурал зарласан тухай Бага хурлын гишүүдэд мэдэгдсэн байна.
- 18.5. Намын Бага хурлыг Бага хурлын гишүүдийн гуравны хоёр эсвэл Удирдах зөвлөл, намын дарга зарлан хуралдуулж болно.
- 18.6. Намын Бага хурлыг хурлаас сонгогдсон дарга удирдана.

- 18.7. Намын Бага хурлын гишүүдийн гуравны хоёроос дээш гишүүн оролцож байгаа бол Бага хурлыг хүчинтэйд тооцно. Бага хуралд оролцогч гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана.
- 18.8. Намын Бага хурлын гишүүний эрх үүргийг намын дүрэм, Улс төрийн намын тухай хууль тогтоомжийн хүрээнд журмаар зохицуулна.
- 18.9. Намын Бага хурлын эрх, үүрэг
- 18.9.1. Намын Их Хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага болох Бага Хурал шийдвэрлэж болно.
- 18.9.2. Намын Даргыг намын Бага хурлаас нууц санал хураалтаар сонгоно.
- 18.9.3. Намын Ерөнхий нарийн бичгийн даргыг Бага хурлаас нууц санал хураалтаар сонгоно.
- 18.9.4. УЗ-ийн гишүүдийг сонгох.
- 18.9.5. Тойрог, Нийслэлийн намын хорооны даргыг намын Бага хурлаас нууц санал хураалтаар сонгоно.
- 18.9.6. Намын бүх шатны байгууллага, удирдах бүрэлдэхүүнийг сонгох журмыг тогтоох.
- 18.9.7. Намаас УИХ-ын болон Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх, ёсчлон батламжлах.
- 18.9.8. УИХ-ын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөр батлах.
- 18.9.9. Монгол улсын Ерөнхий сайдаар томилуулах санал гаргах.
- 18.9.10. Бага хурлын бүрэлдэхүүнд орон гарвал нөхөн сонгох.

19. ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ХОРОО /ХЕХ/

- 19.1. ХЕХ-г намын Их хурлаас 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр дараагийн Их хурал хүртэлх хугацаагаар сонгоно. ХЕХ-ны даргыг ХЕХ-ны гишүүд дотроосоо сонгоно.
- 19.2. ХЕХ хараат бус бие даасан байна.
- 19.3. Тойрог, нийслэлийн намын хороонд Хяналтын хэлтэс, Аймаг, дүүргийн намын хороонд хяналтын хэсэг байгуулж болно.
- 19.4. ХЕХ-г түүний дарга эсвэл гишүүдийн олонхийн саналаар зарлан хуралдуулна. ХЕХ-ны дарга хурлыг удирдана.

- 19.5.ХЕХ-ны гишүүдийн олонхи нь оролцсоноор хүчинтэйд тооцож, гишүүдийн олонхийн саналаар дүгнэлт гаргаж, шийдвэрлэж тогтоол гаргана.
- 19.6.ХЕХ-ны хурлын тэмдэглэлд хуралдаан даргалагч, тогтоолд хуралдаанд оролцсон нийт гишүүд гарын үсэг зурна.
- 19.7.ХЕХ дараах эрх үүргийн хүрээнд хяналт тавина.
- 19.7.1. Намын дүрмийн хэрэгжилт, намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа.
- 19.7.2. Намын гишүүд, сонгуульт гишүүн болон намаас санал болгон сонгогдож, томилогдсон албан тушаалтны ёс зүйн байдал.
- 19.7.3. Намын гишүүний гаргасан гомдол, саналыг хэлэлцэх.
- 19.7.4. Дотоод арбитрын хорооноос гаргасан тайлбар, саналыг хэлэлцэж дүгнэлт гаргана.
- 19.8.ХЕХ дотроо дараах албатай байж болно. Үүнд:
- 19.8.1. Ёс зүйн алба;
- 19.8.2. Санхүүгийн алба.
- 19.8.3. ХЕХ-ны дотоод албаны үйл ажиллагааг журмаар зохицуулна.

20. УДИРДАХ ЗӨВЛӨЛ /УЗ/

- 20.1.УЗ нь Бага хурлын гишүүд, намын удирдлага УИХ-ын гишүүдээс бүрдсэн 9-13 гишүүнтэй байна. УЗ-ийн бүрэлдэхүүнийг намын Бага хурлаас сонгоно.
- 20.2.УЗ-ийн гишүүдийн 20-оос доошгүй хувийг эмэгтэйчүүдийн төлөөлөл бүрдүүлнэ.
- 20.3.УЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулна. Намын дарга эсвэл ЕНБД УЗ-ийн хуралдааныг зарлан хуралдуулж болно. УЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар зарлан хуралдуулж болно. Намын ЕНБД хурлыг даргална. ЕНБД-ын эзгүйд түүний зөвшөөрөл шийдвэрээр аль нэг нарийн бичгийн дарга УЗ-ийн хурлыг удирдана.
- 20.4.УЗ-ийн хуралдаан гишүүдийн олонхи оролцсон бол хүчинтэйд тооцож гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.
- 20.5.Намын даргын санаачлагаар УЗ-ийг зөвлөх гишүүдээр өргөтгөн хуралдуулж болно.
- 20.6.УЗ дараах асуудлаар шийдвэр гаргана:

20.6.1. Бага хурлаас эрх шилжсэн асуудлаар шийдвэр гаргах.

20.6.2. Намын Их, Бага хурлын шийдвэрийн гүйцэтгэлийг хангаж, намын өдөр тутмын байнгын ажиллагааг хангах.

20.6.3. Намын санхүү төсвийг баталж, холбогдох намын байгууллага, албан тушаалтны ажилд хяналт тавих.

20.6.4. Намын бүх шатны байгууллагын уялдаа холбоог хангах.

21.ДОТООД АРБИТРЫН ХОРОО /ДАХ/

21.1.ДАХ-ны гишүүдийг 3 хүний бүрэлдэхүүнтэй намын Бага хурлаас ил санал хураах эсвэл санал нэгдэх зарчмаар сонгоно.

21.2.ДАХ нь ХЕХ-оос гарсан дүгнэлт, шийдвэртэй холбоотой үүсэх маргаан болон намын дүрэмтэй холбоотой үүсэн гарах аливаа маргааныг намын дүрмийн хүрээнд нягтлан хэлэлцэж, ХЕХ-нд тайлбар, санал хүргүүлнэ.

22.НАМЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА МЭДЛЭГ ОНОЛЫН НЭГДЭЛ /МОН/

22.1.Намын дэргэд улс төр, эдийн засаг, шинжлэх ухааны чиглэлээр эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн Эрдэм шинжилгээний зөвлөх байгууллага Мэдлэг Онолын Нэгдэл /МОН/ ажиллана.

22.2.МОН-ийн зохион байгуулалт, үйл ажиллагааг журмаар зохицуулна.

22.3.МОН-ийн даргыг намын Удирдах Зөвлөлөөс сонгоно.

22.4.МОН нь Зөвлөлтэй байна. МОН-ийн Зөвлөлийн бүрэлдэхүүнийг МОН-ийн дарга өөрөө томилно.

22.5.Тус зөвлөл нь ЗОН-ын бүх шатны удирдлагад нэр дэвшигч, УИХ болон бүх шатны орон нутгийн сонгуульд нэр дэвших боловсон хүчнийг бүрдүүлэх, бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.

22.6.МОН нь Зөвлөлдөх хуралтай /ЗХ/ байна. Зөвлөлдөх хурал нь ЗОН-ын бүх шатны удирдлагад нэр дэвшигч, УИХ болон бүх шатны орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдээс бүрдэнэ.

22.7.МОН-ийн Зөвлөлдөх хурлын гишүүд буюу ЗОН-ын бүх шатны удирдлагад нэр дэвшигч, УИХ болон бүх шатны орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нь МОН-ээс зохион байгуулах эрдэм шинжилгээний хурал, сургалт, судалгаа, үйл ажиллагаанд оролцох үүрэгтэй.

22.8.МОН-ээс ЗОН-ын бүх шатны удирдлагад нэр дэвшигч, УИХ-ын болон бүх шатны орон нутгийн сонгуульд нэр дэвших хүмүүсийн талаар Бага хуралд санал оруулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОНГУУЛЬД НЭР ДЭВШҮҮЛЭХ

23. Хүйсийн тэгш байдлыг хангах

23.1. Намын бүх шатанд эмэгтэйчүүдийн төлөөллийн суудал хадгалах квоттой байх, намын хүний нөөцийн боломжинд тулгуурлан эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх.

23.2. Намын Бага хурал, УЗ-ийн гишүүдийг сонгохдоо гишүүдийн 20-оос доошгүй хувийг эмэгтэйчүүдийн төлөөллөөс бүрдүүлнэ.

23.3. УИХ-ын болон бүх шатны орон нутгийн сонгуульд намаас нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувийг эмэгтэйчүүдийн төлөөллөөс бүрдүүлнэ.

24. Намаас бүх шатны сонгуульд нэр дэвших боловсон хүчнийг шилж сонгох шалгуурыг МОН-ээс боловсруулж, журмаар зохицуулна. Журмыг Удирдах Зөвлөлөөр хэлэлцэж батална.

25. УИХ болон бүх шатны орон нутгийн сонгуульд нэр дэвших гишүүдийг сонгох үйл ажиллагааг Бага хурлаас баталсан журмын дагуу явуулна.

26. Бага хурал хуульд заасан журмын дагуу шийдвэр гаргаж, нэр дэвшигчдийг сонгуулийн холбогдох байгууллагад бүртгүүлэх ажлыг УЗ зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ НАМЫН ХӨРӨНГӨ, САНХҮҮ

27. Намын эд хөрөнгөд үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө байна. Намын хөрөнгөд дараах зүйл хамаарна:

27.1. Гишүүний татвар.

27.2. Гишүүн, талархан дэмжигч этгээд, хуулийн этгээдээс өгсөн хандив.

27.3. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг.

27.4. Намын бэлэгдэл бүхий бэлэг дурсгалын зүйлс, намын өмчлөлд байгаа эд юмс.

- 27.5. Намын хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны орлого.
- 27.6. Өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олсон орлого.
- 27.7. Намын мөнгөн хөрөнгийг банкинд хадгалсан хүү.
- 27.8. Хуульд зааснаас бусад хэлбэрээр ашиг олох үйл ажиллагаа эрхлэхгүй.
28. Гишүүний татвар, хандив
- 28.1. Намын гишүүний болон сонгуульт гишүүний татварын хэмжээ, санхүүгийн журмыг намын Удирдах Зөвлөлийн хурлаас батална.
- 28.2. Намын гишүүд, дэмжигчид үзэл бодол, итгэл үнэмшлээрээ намын үйл ажиллагааг дэмжин сайн дурын үндсэн дээр хуульд заасан хэмжээний хүрээнд хандив өгч болно.
- 28.3. Хандивыг мөнгөн бус хэлбэрээр өгвөл түүнийг мөнгөн хэлбэрт шилжүүлэн тооцно.
- 28.4. Хуулийн этгээд, ард олноос намд зориулж өгөх хандивын дээд хэмжээ хуульд заасан хэмжээнээс хэтэрч болохгүй. Намд хандив өгсний төлөө албан тушаал, хувийн эрх ашиг хөөцөлдөх, шахалт үзүүлэхийг хориглоно.
- 28.5. Улс төрийн намын тухай хуулийн 18.7-д заасан этгээдээс хандив авахгүй.
- 28.6. Гишүүний татвар болон хандивыг зөвхөн намын дансруу шилжүүлнэ. Шилжүүлгийн мэдээлэл, утга хэсэгт овог нэр, регистрийн дугаар, утасны дугаараа бичнэ.
29. Намын орлогын зарцуулалт, хяналт
- 29.1. Намын орлогыг зөвхөн намын үйл ажиллагаа, мөрийн хөтөлбөр, дүрэмд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулна.
- 29.2. Бүх шатны намын байгууллага тогтсон хугацаанд санхүүгийн тайлангаа УЗ-д ирүүлнэ.
- 29.3. Намын төв байгууллага нь харьяа байгууллагын санхүүгийн тайлан гаргасны дараа нэгдсэн тайлан гаргана.
- 29.4. Намын бүх шатны байгууллага, хөрөнгийн зарцуулалтын талаар нам нээлттэй цахим данс хөтөлнө.
- 29.5. Намын орлогын зарцуулалтанд ХЕХ хяналт тавина.
- 29.6. Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.

29.7. Намын дарга намын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд захиран зарцуулах эрхтэйгээр оролцохгүй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ УИХ ДАХЬ НАМЫН БҮЛЭГ

30. Намын бүлэг нь ЗОН-аас УИХ-д нэр дэвшиж сонгогдсон УИХ-ын гишүүдээс бүрдэнэ. Бүлэг дотроосоо бүлгийн даргыг сонгоно.
31. Намын бүлэг нь Монгол Улсын хууль тогтоомж, намын дүрэм, мөрийн хөтөлбөрийн хүрээнд бие даан ажиллана.
32. УИХ-д намын байр суурийг илэрхийлэх, намын бодлого, шийдвэрийг УИХ-аас гарах хууль, тогтоол, шийдвэрт тусгах.
33. Намын бүлэг гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
34. Намын бүлэг үйл ажиллагааныхаа талаар намын Бага хурал, УЗ-д мэдээлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ НАМЫН УДИРДЛАГА

36. ЗОН-ын дарга, түүний бүрэн эрх
- 36.1. ЗОН-ын дарга нь намын тэргүүн мөн. Намын үзэл баримтлалыг баримтлагч, эв нэгдлийг сахигч, чөлөөт өрсөлдөөнийг хангагч байна.
- 36.2. ЗОН-ыг дотоод, гадаадад төлөөлнө.
- 36.3. ЗОН-ын даргын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. УИХ-ын сонгуульд ахисан тооны суудал авсан тохиолдолд бүрэн эрхийн хугацаа дахин 4 жил сунгагдсанд тооцогдоно.
- 36.4. УИХ-ын сонгуульд олонхийн суудалтай болсон тохиолдолд ЗОН-ын даргыг Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ.
37. Зон Олны намын Ерөнхий нарийн бичгийн дарга
- 37.1. УЗ-ийн хуралдааныг даргалах, түүнээс гарсан шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.
- 37.2. ЗАА-ны бүтэц, ажилтан, түүний даргыг томилох, удирдан зохион байгуулах.
- 37.3. ЗОН-ын даргын эзгүйд болон түүнийг албан үүргээ гүйцэтгэх боломжгүй тохиолдолд бүрэн эрхийг нь хэрэгжүүлэх.

38. Зон Олны намын дэргэдэх Мэдлэг Онолын Нэгдэл /МОН/-ийн дарга
- 38.1. МОН-ийн дарга нь намын боловсон хүчнийг бүрдүүлэх, бэлтгэх, намын гишүүд болон сонгогчдын улс төр, шинжлэх ухааны боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн МОН-ийн үйл ажиллагааг удирдана.
- 38.2. ЗОН-ын удирдлагуудад МОН зөвлөх үйл ажиллагааг удирдана.
- 38.3. ЗОН-ын дээд шагнал “Их Монгол” одон олгох хүнийг УЗ-д санал оруулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД

39. ЗОН нь Монгол улсын нийслэл, 21 аймаг, дүүрэг, сумдуудыг хамарсан намын дотоод үйл ажиллагаандаа нэгдсэн цахим систем ашиглана. Тус системийг “ЦАХИМ НАМ” гэж нэрлэнэ.
40. Намын заавал тэмдэглэх бахархалт, танин мэдэхүйн ойн баярууд:
- Их Монгол улс байгуулагдсан 1206 оныг жил бүрийн 9-р сарын 9-нд хүндэтгэл үзүүлж, тэмдэглэнэ.
 - Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан 1911 оны 12-р сарын 29-ний өдрийг жил бүрийн тухайн өдөрт нь хүндэтгэл үзүүлж, тэмдэглэнэ.
 - Төрийн далбааны өдөр 7-р сарын 10-ны өдрийг жил бүр тухайн өдөрт нь хүндэтгэл үзүүлж, тэмдэглэнэ.
 - Зон Олны нам анх үүсгэн байгуулагдсан 2016 оны 12-р сарын 06-ны өдрийг жил бүрийн тухайн өдөрт нь тэмдэглэнэ.
41. ЗОН дээд шагналтай байна. ЗОН-ын дээд шагнал нь “Их Монгол” одон байна. Шагналд тодорхойлох, шагнах ажиллагааг журмаар зохицуулна. Журмыг Удирдах зөвлөлийн хурлаас батална.
42. Зон Олны нам нь бүх шатандаа нэг загварын албан хуудас ашиглана.
43. Зон Олны нам нь Улс төрийн намын тухай хуулийн 16.2.4 дэх хэсэгт заасан бэлэгдэл бүхий бэлэг дурсгалын зүйлсийг бүтээх тогтсон журамтай байна.
44. Бэлгэдэл, туг далбаа, тамга тэмдэг, албан хуудас үйлдэх, хэрэглэх журамтай байна.
45. Энэхүү намын дүрэм, мөрийн хөтөлбөрийн хамт батлагдаж, Дээд Шүүхэд бүртгүүлснээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.